

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН ДАХЬ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛТ ОЙЛГОЛТ

Доктор (Ph.D) Г.Алтансүх
ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн

Түлхүүр үг: хоёр гар, килгүн, уламжлалт ойлголт, засаг захиргааны зохион байгуулалт

Засаг захиргааны зохион байгуулалт бол удирдагчийн эрх мэдлээ хэрэгжүүлдэг тогтолцоо учир нэгж бүр тодорхой эрх, үүрэгтэй. Эрх, үүргээ хэрэгжүүлэх шаталсан бүтэцтэй, тусгай газар нутагтай, нийгмийн олон бүлэг, давхрааг өөртөө багтаасан зохион байгуулалт байх ёстой. Ямар ч засаг захиргааны бүтэц, нийгмийн зохион байгуулалт өөрийн гэсэн төрийн байгуулалтын үзэл санаа, удирдлагын тогтолцооны түүхэн уламжлал дээр тулгуурладаг. Гэвч дундад зууны үеийн монголын түүхийг судалсан өрнийн эрдэмтэд XII зууны үеийн монголчуудын нийгмийн байгуулалтыг овог, аймаг, цусан төрлийн холбоонд суурилсан бөгөөд зэргэлдээх суурин иргэншлийн нөлөөгөөр төр байгуулсан хэмээн үзэж “Тусгалын төр”, “Зээлдмэл төр” хэмээх ойлголтыг бий болгожээ.¹ Бидний санахаар ямар нэгэн төр ёсны уламжлалгүй, төр байгуулах үзэл онолгүй, өөрийн гэсэн төр ёсны үзэл суртал, ойлголтгүй ард түмний байгуулсан төрийг л “Тусгалын төр”, “Зээлдмэл төр” гэх мэтчилэн тодорхойлж болох юм.

Монгол төрийн түүхэн үндсийг монголчуудын ертөнцийг үзэх үзэл, улс төрийн үзэл суртал, төр байгуулах уламжлалт арга ухаанаас эрэлхийлэх нь зүйтэй юм. Тиймээс бид энэхүү илтгэлийн хүрээнд XII зууны монголчуудын төрийн байгуулалтын уламжлалт арга ухаан, үзэл онол, тухайн үеийн монгол нутагт байсан төрт улсуудын дотоод зохион байгуулалтын асуудлыг хөндөх болно.

XII зууны монгол нутаг дахь улсуудын засаг захиргааны зохион байгуулалтын хамгийн том нэгжийн тухай ерөнхий хоёр үзэлт байдаг. Эхний үзэл нь, Марксист түүх бичлэг, Нийгмийн хувьслын онолын хүрээнд боловсруулагдсан *Gens* (овог) – *Phratry* (хоёр ба түүнээс олон *gen*-үүдээс бүрддэг) – *Tribe* (хоёр ба түүнээс олон *Phratry*-гаас бүрдэнэ) – *Tribe federation* (хоёр ба түүнээс дээш *Tribe*-уудаас бүрддэг)” гэсэн загварын дагуу XII зууны монголчуудын улс төрийн бүтцийн хамгийн дээд нэгж нь *tribe* эсвэл *tribe federation* гэж үздэг. XII зууны үеийн монголчуудын нийгмийн байгууллыг ийнхүү загварчилсан гол судалгаа бол В.Я.Владимирцовын “Монголчуудын нийгмийн байгуулал: Нүүдлийн феодализм” хэмээх бүтээл юм. Тэрээр сурвалжид *irgen* ба *ulus* хэмээн үгээр тодорхойлогдсон XII зууны үеийн

¹ Barfield T.J. The Perilous Frontier: Nomadic Empires and China. Cambridge, Mass. and Oxford UK, Basil Blackwell. 1989; Khazanov A.M. Nomads and the Outside World. Translated by Julia Crookenden, The University of Wisconsin Press. 1994; London. Cosmo N.D. Ancient China and Its Enemies The Rise of Nomadic Power in East Asian History. Cambridge, Cambridge University Press. United Kingdom. 2002

монголчуудын улс төрийн бүтцийн дотоод зохион байгуулалтыг “овог (obox) > овгуудын нэгдлээр *ulus* ба *irgen* гэж нэрлэдэг улс төрийн шинэ нэгдлүүд бүрэлдсэн.” гэдэг ерөнхий загварчлалыг гаргажээ.² Энэ үндсэн загварчлал нь Марксист түүх бичлэгийн үзэл суртлын нөлөөгөөр Монголын түүх бичлэгт нутагшсан юм.

Хоёрдугаар үзэлт нь аж ахуй эрхлэлтийн арга хэлбэр, хэрэгцээ шаардлагад үндэслэсэн байдаг. Тодорхой хэлбэл, XII зууны монгол нутаг дахь улсуудын нийгмийн байгууллын үндсэн нэгж нь *güre'en* мөн гэсэн үзэлд тулгуурласан гэж ойлгож болно. Энэ санааг анх Паул Давид Буэлл (Paul David Buell) 1977 онд бичсэн докторын судалгааны ажилдаа гаргасан байдаг:

“Нүүдлийн мал аж ахуйн хөдөлмөр хоршилт ба хамгаалалтын зорилгоор нэгдсэн хоёр ба түүнээс дээш *ayil*-ын нэгдэл байсан. Энэ нэгдэл бэлчээр усны хангалттай нутагт илүү том байж болдог.³ ... XII зууны төгсгөл ба XIII зууны эхэнд нэг нэгнээс хамааралгүй, бие даасан хэлбэртэй байсан Монголын нийгмийн байгуулалын хамгийн жижиг нэгж болох *ayil*, *bölök irgen* нь илүү тогтвортой том нэгдэл болж өөрчлөгдсөн. Энэ өөрчлөлтийг манай сурвалжуудад хэд хэдэн янзаар тэмдэглэгджээ. Тэдгээрээс хамгийн чухал нь *güre'en* хэмээх ойлголт ба түүний утга юм. *Güre'en*-ий хамгийн эртний утга нь төвдөө малын хэвтэртэй хороо байдлаар буудаллах хэлбэрээс амархан ойлгогдоно. XII зууны төгсгөлд *güre'en* хоёр дахь утгаа олж авснаар “түр зуурын хугацааны хамгаалалтын камп” гэсэн утга заадаг болжээ. Энэ нэр томъёогоор ерөнхийдөө нийгэм, улс төрийн нэгж, цэргийн хамгаалалтын хүрээг нэрлэж байв. ... XIII зууны эхэн гэхэд бүхий л монгол туургатан, Тэмүжин, Жамуха нарын удирдлагад байсан иргэд төдийгүй эзэнт гүрнийг бүрэлдүүлсэн овог аймгууд бүгдээрээ *güre'en* зохион байгуулалттай байсан юм.⁴

П.Д.Буэллийн судалгааны дараа манай түүхч Ш.Нацагдорж 1978 онд хэвлүүлсэн “Монголын феодализмын үндсэн замнал” бүтээлдээ “хүрээ нь XII-XIII зууны үед нийгмийн байгууллын талаар их үүрэг гүйцэтгэсэн нь маргаангүй” хэмээгээд тухайн үеийн хүрээг “феодалуудын аж ахуйн гол мөхлөг, феодалын мөлжлөгийн гол хэлбэр”⁵ гэж тодорхойлжээ. Эдгээр судалгаанууд бол XII зууны монгол нутаг дахь нүүдэлчдийн нийгмийн байгууллын үндсэн суурь нэгж *güre'en* болохыг тодорхойлсон анхны судалгаанууд байв. Энэ үзэл санааг хожим Ж.Гэрэлбадрах нар үргэлжлүүлэн хөгжүүлж тусгай өгүүлэл бичээд “XII зууны монгол нутаг дахь улсууд нь засаг захиргааны зохион байгуулалтын хувьд гурван гарт хуваагддаг. Гар тус бүр

² Владимирцов Б.Я. Общественный строй монголов: Монгольский кочевой феодализм. Ленинград., 1934. с. 59

³ Buell, Paul D. Tribe, Qan and Ulus in Early Mongol China: Some Prolegomena to Yüan History. Unpublished doctoral dissertation, University of Washington. 1977. P 14.

⁴ Buell, Paul D. Tribe, Qan and Ulus in Early Mongol China: Some Prolegomena to Yüan History. Unpublished doctoral dissertation, University of Washington. 1977. P 26.

⁵ Нацагдорж Ш. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978. Тал 45.

дотроо хүрэнүүдэд хуваагддаг” гэсэн шинэ бүтцийг гаргасан байдаг.⁶ Бид мөн энэ үзлийг дэмжиж байв.⁷

XII зууны монголчуудын төрийн байгуулал, удирдлагын тогтолцооны тухай судалгаа хийхдээ төрийн зохион байгуулалтын уламжлал ба өгүүлэн буй үеийн улс төрчдийн төрийн байгуулалтын тухай ойлголтыг судлан үзэх шаардлагатай юм. XII зууны нөлөө бүхий язгууртнуудын төр ба төрийн бүтцийн тухай үзэл ойлголтыг илэрхийлэх баримтууд Монголын нууц товчоо, Судрын чуулган зэрэг сурвалжуудад тааралдаж байна.

Хааны ордыг сурвалжид “Их гэр тэрэг” хэмээн тэмдэглэдэг бөгөөд хаан тус нүүдлийн ордноосоо улсыг удирдана. Энэ тухай манай сурвалжид:

ja'arin irejü nadur nidün-dür-iyen üje'ülba qo'aqcin üni'en irejü jamuqa-yi horciju yabuju ger tergen inu mürgüle'et jamuqa- yi mürgüjü öre'ele eber-iyen qiquraju sof[1]jir eberty bolju eber minu aca ke'en ke'en jamuqa-yin jü[k] mö'ören mö'ören siro'ai sacun sacun bayimu muqular qo'a hümer yeke gerlüge de'ere ergüjü köljü jüküjü temüjin-ü qoyinaca yeke terge'ür-iyer mö'ören mö'ören ayisurun tenggiri qajar eyetü[l] düjü temüjin-i ulus-un ejen boltuqai ke'en ulus te'eji a[b] cu ayisu ke'en ja'arit nidün-tür üje'ü[l]jü ...⁸
“Заарин ирж, надад нүдэндээ үзүүлэв. Хуагчин үнээ ирж Жамухыг орчин явж, гэр тэргийг нь мөргөлөөд Жамухыг мөргөж өрөөл эврээ хугалаж, солжир эвэрт болж өвөр миний ац хэмээн хэмээн Жамухын зүг мөөрөн мөөрөн шороо сацан баймуй. Мухулар хуа үхэр их гэр лүгээ дээр өргөж хөлж, зүтгэж Тэмүжинийг хойноос их тэргүүрээр мөөрөн мөөрөн айсуйдаа тэнгэр, газар этэлдэж Тэмүжинийг улсын эзэн болтугай хэмээн тээж авч айсуй хэмээн зайрад нүдэнд үзүүлж...”

хэмээн өгүүлдэг. Энэ мэдээнд тэргэнд байрлах “Их гэр – Орд”-ыг улстай зүйрлэж байгаа бол дараах баримтанд улсыг удирдах ажлыг “Их гэр тэрэг”-ийг жолоодох явдалтай зүйрлэн өгүүлж байна.

qan ecige minu bi cö'en ber bö'esü olon-ni ülü eri'ülgü büle'e mawui ber bö'esü sayin-i ülü eri'ülgü büle'e bi qoyar kil<ü>gütei tergen nökö'e kil<ü>gü-ben ququra'asu hümer inu jikdün yadayu tere metü nökö'e kil<ü>gün cinu bi ese-'ü⁹ “Хан эцэг минь Би цөөн бэр бөгөөс олныг үл эрэх бөлгөө, муу бэр бөгөөс сайхныг үл эрэх бөлгөө би. Хоёр аралтай тэрэг нөгөө арлаа хугарваас үхэр нь зүтгэн ядую. Тэр мэт нөгөө арал чинь би биш гэж үү?”

Хаан улсаа Их гэр тэрэгний хоёр гар мэт хоёр жигүүрт хувааж удирдах ёстой гэсэн ерөнхий ойлголт Тэмүжин, Тоорил хан тэргүүтэй нөлөө бүхий язгууртнуудад байсан дээрх мэдээнээс ойлгогдож байна. Гэр тэрэгний хоёр арлын нэг хугарахыг улсыг удирдах хоёр гарын нэг (*Kağan* ба *Taiji*, *Kağan* ба *Yabgu* г.м.) үгүй болсонтой зүйрлэдэг уламжлалт ойлголт, тогтсон зүйрлэл

⁶ Гэрэлбадрах Ж. Монголчуудын хүрээ гэж юу вэ?, Acta Historica. Tom 16. Fasc 13. УБ., 2014.

⁷ Алтансүх Г. XII зууны Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын асуудалд. Acta historica. Tomus 15. УБ., 2014.

⁸ Rachewiltz, I. De. Index to the Secret History of the Mongols. Bloomington. 1972. P 50.

⁹ Rachewiltz, I. De. Index to the Secret History of the Mongols. Bloomington., 1972. P 87.

тухайн үеийн монголчуудад байжээ. Дээрх мэдээнээс үзэхэд 1202 онд болсон эцэг, хөвүүн бололцох ёслолоор Хэрэйд ба Монгол улсын төр нэгдсэн бөгөөд нэгдсэн улсын нэг гарыг Чингис хаан, нөгөө гарыг Ван хан удирдаж байсан нь бололтой байна. Эдгээр баримт XII зууны монголчуудын төрийн байгуулалтын тухай үндсэн ойлголт нь эртний нүүдэлчдийн хоёр гарын тогтолцооноос уламжлалтай байсныг харуулж байгаа юм.

Дотоод азийн нүүдэлчин ард түмнүүдийн төрийг байгуулах уламжлалт арга нь “Хоёр гарын тогтолцоо” байсныг XX зууны эхэн үед Зияа Гөкалп:

“Адинжа ханы хоёр хөвүүн байсан. Нэгийнх нь нэрийг Монгол, нөгөөгийнх нь нэрийг Татар гэдэг. Тэр үед түрэгүүд Монгол болон Татар гэсэн хоёр хэсэгт хуваагдан хоорондоо дайсагнаж байжээ. Энэ үгнүүдийн уг үндсийг хайж үзвэл нэгдэх нь “Бугу эл - Buğu ili”, хоёр дахь нь “Тат эр – Tat Er” гэдэг нь өндөр магадлалтай байна. Огузын түүхийн үндэс нь монголчууд ба татарууд хоорондын урт хугацааны домогт тэмцэл юм. Энэ тэмцэл түрэгийн Шахнамений сэдэв болдог. ... Түрэгүүд хүрээний үүдийг үргэлж наран ургах зүгт харуулдаг учраас өмнө талд баруун гар, хойд талд зүүн гар байдаг. Энэ хэлбэрээр “Баруун ба Зүүн гар”-ын ойлголт бий болсон”¹⁰

гэж тайлбарласан байдаг.

Түүхч Никола Ди Космо “Дотоод азид байгуулагдсан бүхий л төрт улсуудаас төрийн зохион байгуулалтын хувьд нутаг дэвсгэрийг хоёр гарт хуваах (зүүн ба баруун, өмнөд ба умард г.м.), цэргийг аравтын тогтолцоогоор зохион байгуулах (10, 100, 1000 ... гэх мэт нэгжүүдэд хуваах), тодорхой тооны том албан тушаалтнуудтай байх, чуулган чуулдаг сайдуудтай байх зэрэг онцлогуудыг харж болно”¹¹ гэжээ.

Сы Ма Чяний бичсэн “Түүхэн тэмдэглэл” зохиолоос үзвэл зүүн, баруун хоёр гарын зохион байгуулалтай байсан нүүдэлчдийн анхны төрт улс Хүннү гүрэн байжээ. Тэрээр:

“Модууд хүрээд Хүннү хамгаас хүчтэй болов. Хойд И-г эрхшээж өмнө зүг дундад оронтой дайсагнаж улс гүрний тодорхой зэрэг дэвтэй болов. Тэдний улсын удам залгасан түшмэлийн зэргийг мэдснээрээ тэмдэглэв. Зүүн, баруун мэргэн ван, зүүн, баруун гү ли ван, зүүн, баруун өрлөг жанжид, зүүн, баруун да ду вэй, зүүн, баруун өрхийг мэдэгч, зүүн, баруун гү доу хоу тавина. Хүннүд мэргэнийг тү гэ хэмээдэг. Үргэлжид хааны хөвгүүнээр зүүн тү гэ ван тавина. Зүүн, баруун мэргэн вангаас доошоо өрх мэдэгч хүртэл их нь түмэн морьт цэрэгтэй, бага нь хэдэн мянган морьт цэрэгтэй байжээ. Хорин дөрвөн ахлагч нь түмэн морьт цэрэгтэй хэмээн нэр алдаршуулна. Их түшмэд нь үеийн ноёд болой. Ху янь, хөх, шой бү гурав нь цагаан ястны ураг овог болой. Зүүн ван ноёд дорно буй. Шанг гү-гээс цаашлан зүүн зүгт Хуй хэ, Солонгост хүрнэ. Баруун ван ноёд өрнө буй. Шан жюнь-гээс баруун зүгт Роу Зы, Ди, Чян-

¹⁰ Gökalp Z. Makaleler III. Haz. M. Orhan Durusoy. Kültür Bakanlık Yayınları. Ankara. 1977. s. 72.

¹¹ Cosmo N.D. Ancient China and Its Enemies The Rise of Nomadic Power in East Asian History. Cambridge, Cambridge University Press. United Kingdom. 2002. P 177.

д хүрнэ. Шаньюын орд Дай, Юнь жун-д буй. Өөр өөрийн хувиар газартай. Өвс бэлчээр дагаж нүүдэллэнэ. Зүүн, баруун мэрэгэн ван, зүүн, баруун гү зун ван их ван болно. Зүүн, баруун гү доу хоу засагт туслана. Хорин дөрвөн ахлагч өөрсдийн гар доороо мянгат, зуут, аравт, би сяован түшмэл, фен Ду вэй, өрх мэдэгч, чэ чү зэрэг бага ноёдтой.¹²

хэмээн тэмдэглэсэн байна.

Түрэгийн эзэнт улсын төрийн бүтэц, засаг захиргааны зохион байгуулалт нь хаан болон ябгу-гийн гэсэн хоёр гарын тогтолцоонд суурилж байсныг зарим эрдэмтэд “Хосломол бүтэц” гэж нэрлэдэг. Тухайлбал, Туркын эрдэмтэн Ибрахим Кафесоглу “Тэргүүнд томоохон язгууртан (шаньюй, хаан) байж, улсаа баруун, зүүн жиргүүрт хуваан зохион байгуулна. Тус хоёр жигүүр нь төв ордонд харьяалагдаж шаньюй эсвэл хаанд шууд захирагдана. Жигүүрүүдийн тэргүүнд удирдагч байх боловч жинхэнэ тэргүүний удирдлага дор, ноёдын чуулганаар эрх мэдлээ хэрэгжүүлнэ.” хэмээгээд энэхүү хоёр гарын тогтолцоо Дотоод Азийн түрэг гаралтай нүүдэлчдийн төрийн удирдлагын тогтолцооны нэг чухал уламжлал болсныг дараах байдалтай тодорхойлжээ:

Зүүн-Баруун “Хүннү, Табгач, Түрэгийн хаант улс г.м.”

Умард-Өмнөд “Хүннү, Цагаан Хүннү, Түрэг г.м.”

Жихитүүдэд Баруун жигүүр, Зүүн жигүүр

Их-Бага “Булгар, Унгар, Усун”

Гадаад-Дотоод “Огузууд, Булгарууд, Карлукуудад”

Баруун, зүүн Бозок-Үчок “Огузуудад”¹³

Хятан гүрний дотоод зохион байгуулалтын тухай *Liao Shi*-гийн 32-р бүлэгт өгүүлсэн нь:

遥輦阻午可汗二十部:耶律七部; 審密五部; 八部.涅里相阻午可汗, 分三耶律為七, 二審密為五, 并前八部為二十部. 三耶律: 一曰大賀, 二曰遥輦, 三曰世里, 即皇族也. 二審密: 一曰乙室已, 二曰拔里, 即國舅也. 其分部皆未詳; 可知者曰迭刺, 曰乙室, 曰品, 曰楛特, 曰烏隗, 曰突吕不, 曰捏刺, 曰突舉, 又有右大部, 左大部, 凡十逸其二.¹⁴

... (Xu Elina-Qian, 2005, s. 65) “Зуву (Zuwu) хааны хорин *bú* бол, Елюй (*yé lù*) нарын долоон *bú*, Шэнми (*shěn mǐ*) нарын таван *bú*, [Өөрийнх нь] найман *bú*-аас бүрдэнэ. Ниели (*nì lì*) нарын туслалцаатайгаар Зуву хаан гурван Елюй-г долоо хуваасан. Хоёр Шэнми-ийг тав хуваасан. Анх өөрийнхөө найман *bú* дээр нэмээд нийт 20 *bú* болгосон. Гурван Елюй гийн хамгийн томынх нь нэр Дахэ (*Dahe*). Хоёр дахийнх нь нэр Яанион (遥輦 *yáo niǎn*) юм. Гурав дахийнх нь нэр Шили (*世里 shì lì*) юм. Эдгээр бол эзэнт гүрний язгууртан овгууд болно. Хоёр Шэнмигийн эхнийх нь Ейший (*yǐ shì yǐ*), хоёрдугаарх нь Бали (*bá lì*) нэртэй. Эдгээр бол язгууртан овог аймгуудын авгын талынхан юм. Тэдний *bú* салбарууд тодорхой биш. Мэдэгдэж байгаа нь *Díe là*, *Yǐ shì*, *Pín*, *Chǔ tè*, *Wū wěi*


¹² Сы Ма Чянь. Түүхийн тэмдэглэл. Хүннүгийн шастир. (Орчуулсан Батжаргал. Ба). УБ., 2016. Тал 46.

¹³ Kafesoğlu, İ. *Türk Milli Kültürü*. Ötüken. 17. Baskı. İstanbul. 1998. s. 271.

¹⁴ Xu Elina-Qian. Historical Development of the Pre-Dynastic Khitan. (academic dissertation). Helsinki. 2005. P 65.

(kuí), Tū lǚ bù, Niē lá, Tū jǔ гэх мэт билээ. Мөн түүнчлэн тэдэнд (Хятан нарт) 右大部 *yòu dà bù* (Баруун их бу) ve 左大部 *zuǒ dà bù* (Зүүн их бу) байдаг. Тэгээд түүнд нь 10 бу байдаг.” гэсэн байдаг.

Энэ мэдээнээс үзвэл Хятаны язгууртнууд улсаа нийт 20 бу-д хуваасан бөгөөд түүнийгээ *Зүүн их бу*, *Баруун их бу* гэсэн хоёр гарт хуваасан байна. Эртний уламжлалт хоёр гарын тогтолцооны бүтцийг Хятан гүрнээс мөн харж болох ажээ.



1206 онд Чингис хааны байгуулсан Их Монгол улсын засаг захиргааны бүтцийн хамгийн дээд шатлалд Зүүн гар, Баруун гар байсан нь сурвалжуудад тодорхой туссан байдаг. Чингис хаан Их Монгол улсыг байгуулсныхаа дараа *tusatan-a soyurqal öksüi* хэмээн улс байгуулалцан зүтгэгсдэд соёрхол өгөхдөө хамгийн тэргүүнд Боорчу, Мухали хоёрыг урьж оруулаад:

*bo'orcu muqali qoyar jö[b] minu yabutala jiktüjü buru'u-yi minu bayitala itqaju ene oron-tur gürgeba edö'e bürin-ü de'ere sa'uri sa'uju yisün alda[l]-tur bu aldatuqai bo'orcu bara'un qar-un altai derelegün-ü tümen medetügei*¹⁵ “Боорчу, Мухали хоёр зөвийг минь явтал зүтгүүлж, бурууг минь байтал ятгаж энэ оронд хүргэв. Эдүгээ бүрний дээр суурь сууж есөн алдалд бүү алдтугай. Боорчу баруун гарын Алтай дэрлэхүүний түмэн мэдтүгэй.”

*muqali-yin uruq-un uruq-a güртеle güir irgen-ü gui-ong boltuqai ke'en gui-ong nere ökba muqali-gui-ong jewün qar-un qara'un-jidiin-i derelegün-ü tümen medetügei ke'en jarliq bolba*¹⁶ “Мухалигийн ургийн уругт хүртэл гүр иргэний Гүй-Онг болтугай хэмээн Гүй-Онг нэр өгөв. Мухали Гүй Онг зүүн гарын Харагун Жидуны дэрлэхүүн түмэн мэдтүгэй хэмээн зарлиг болов”

Энэ мэдээнд Их Монгол улс дотоод зохион байгуулалтын хувьд хоёр гарт хуваагддаг болохыг тодорхой заажээ. Үүнийг Рашид-ад Дины мэдээ улам тодорхой болгодог. Судрын чуулганд: *أَنجِه به قُول و بَرَاؤُن قَار و جِيُون قَار يعنى قلب و*

¹⁵ Rachewiltz, I. De. Index to the Secret History of the Mongols. Bloomington., 1972. P 117.

¹⁶ Rachewiltz, I. De. Index to the Secret History of the Mongols. Bloomington., 1972. P 118.

(فول) “Ийнхүү гол (فول) 17. جناحين تعلق داشته اند و از راه میراث به یکه نوبان رسیده، صد و یگ هزار نفر، баруун гар (بِرَاوُن قَار) ба улсын зүрхэн хэсэг зүүн гар (جیوُن قَار) хэмээн хуваажээ. Их ноёнд 101.000 иргэнийг өвлүүлэн үлдээсэн.” хэмээн тайлбарладаг. Энд дурдан буй 101.000 иргэн бол Чингис хаан хувийн нэг мянгат, Баруун гарын захирагч Боорчу ноёны удирдлага дахь 38.000 иргэн, Зүүн гарын захирагч Мухали ноёны захиргааны 62.000 иргэнээс бүрдэнэ.

Энэ тухай Судрын чуулганд:

فول- و آن هزاره خاص چینگگیز خان بوده، تمامت ایواغلانان چهار ازدوی بزرگ او، و 18. کسانی که به آن اوردوها تعلق داشتند، یگ هزار نفر хамаарах хувийн мянган юм. (энэ мянгат) Түүний дөрвөн их ордны гэрийн хөвгүүд болон бусад хүмүүсээс бүрдэнэ..”;

میمنه یعنی لشکر دست راست - و مقدم ایشان بُورچی نوبان بوده و سئگوسون یعنی قایم 19. مقام او بُورغول نوبان، سی [و] هشت هزار نفر Баруун гарын өөрөөр хэлбэл Баруун гарын цэргийн удирдагч нь Боорчу ноён. Түүний *sütügüsünü* буюу орлогч, зөвлөх (*kâyim-makamı*) Борохул ноён. 38 мянган иргэнтэй... Тэр үеийн хувийн мянгатууд хэдий том мянган байсан ч мянган хүнээс илүү биш”;

یعنی لشکر دست چپ و به مغولی آن را چُون قار گویند، و مقدم ایشان موقلی گویانگ 20. بوده، و سئگوسون او نایا نوبان از قوم بارین شصت و دو هزار цэргийг Монголоор *je 'ün qar* гэдэг. Тэдний захирагч нь Мухали Гоо Ван байсан. Түүний *sütügüsün* Баарины Наяа ноён юм. 62 мянгантай.”

гэх зэрэг мэдээнүүд байдаг. Эдгээр баримтууд нь 1206 онд байгуулсан Их Монгол улсын удирлагын тогтолцооны хамгийн том нэгж нь зүүн, баруун гар болохыг нотолж байгаа юм. Өөрөөр хэлбэл Их Монгол улсын төрийн удирдлагын тогтолцоо “Их гэр тэрэгний хоёр арал” мэт хоёр гарт хуваагдаж байсан гэж ойлгож болно.

Монголын нууц товчооны мэдээ ёсоор Чингис хаан өөрийн эх Өгэлүн болон отгон дүү Тэмүгэ Отчигин ноёнд 10.000 иргэн, том хөвүүн Жүчид 9.000 иргэн, Цагадайд 8.000 иргэн, Өгэдэйд 5.000 иргэн, Тулуйд 5.000 иргэн, дүү Хасарт 4.000 иргэн, Алчидайд 2.000 иргэн, Бэлгүдэйд 1.500 иргэн өгчээ.²¹ Өөрийн ургийн мэдэлд нийт 44.500 иргэн өгчээ. Судрын чуулганы мэдээлж буйгаар Чингис хаан өөрийн урагтаа 28.000 иргэн мэдүүлсэн байдаг. Өгэлүн эхэд 3.000 иргэн, Отчигинд 5.000 иргэн, Хасарын урагт 1.000 иргэн, Хачигуны урагт 3.000 иргэн, Жүчийн урагт 4.000 иргэн, Цагадайд 4.000 иргэн, Өгэдэйд 4.000 иргэн, отгон хөвүүн Хөлгэндээ 4.000 иргэн өгчээ. Эдгээр баримтаас

¹⁷ Reşîdüddîn Fazlullâh Hemedanî. Câmi'ut-tevârîh, Tashih Muhammed Rûşen ve Mustafa Müsevî. C.I, Enteşerat-i Elborz, Tahrân. 1373. s. 592.

¹⁸ Reşîdüddîn Fazlullâh Hemedanî. Câmi'ut-tevârîh, Tashih Muhammed Rûşen ve Mustafa Müsevî. C.I, Enteşerat-i Elborz, Tahrân. 1373. s. 592.

¹⁹ Reşîdüddîn Fazlullâh Hemedanî. Câmi'ut-tevârîh, Tashih Muhammed Rûşen ve Mustafa Müsevî. C.I, Enteşerat-i Elborz, Tahrân. 1373. s. 594.

²⁰ Reşîdüddîn Fazlullâh Hemedanî. Câmi'ut-tevârîh, Tashih Muhammed Rûşen ve Mustafa Müsevî. C.I, Enteşerat-i Elborz, Tahrân. 1373. s. 599.

²¹ Rachewiltz, I. De. Index to the Secret History of the Mongols. Bloomington., 1972. P 139.

үзэхэд Чингис хаан өөрийн урагтаа 28-45 мянган буюу 3-4 түмэн иргэнийг захируулжээ. Энэ нь алтан ургийнхны “өмч иргэн” хэлбэрээр Их Монгол улс дахь Чингис хааны ургийнханы гол хүч болж байсан. Алтан ургийнхны өмч иргэнээс бусад бүх иргэдийг хоёр гарт хуваан захирсан гэж ойлгогдож байна.




Аливаа зүйлийн уламжлалыг өмнөх түүхэн цаг үеэс улируулан судлахаас гадна хожмын түүхэн баримтаас урагш хөөж үзэх аргыг түүхийн судалгаанд ашигладаг. XV-XVI зууны үеийн Монгол төрийн засаг захиргааны зохион байгуулалтыг үзвэл мөн “Хоёр гар”-ын тогтолцоо тодорхой ажиглагддаг. XV зууны эхэнд *тайж* (taizi) хааны дараах эрх мэдэлтэн байсан бөгөөд хаан үгүй болоход тайжийг ханд өргөмжлөөд, шинэ тайжийг нөхөн томилдог ёс хадгалагдсаар байсныг 1416 оны Дөрвөн ойрадын ноёдын чуулганаас гаргасан “Хоромхон нэрт балгасаныг барих болов. Хуух алаг шарыг цохих болов. Ачай тайжийг хан өргөх болов. Аругтай хөвгүүнийг тайж болгох болов.”²² гэсэн шийдвэр тодорхой хэмжээнд харуулдаг. Эзэнт гүрний дараах монголчуудад хоёр гарын зохион байгуулалт уламжлагдан хадгалагдсаар байсан билээ.

Энэ үеийн бүх монголчуудыг хаан захирах боловч улсаа Баруун монгол, Зүүн монгол гэж хоёр хуваана. Зүүн монголыг хаан удирдана. Баруун монголыг хаанаас томилсон *тайж* удирддаг байжээ. Зүүн Монгол нь дотроо Зүүн болон Баруун гарт хуваагдана. Зүүн гарыг хаан, Баруун гарыг хаанаас томилсон Жонон (*jin wàng*) удирдана. XV зууны үеийн монголчууд нийт 10 түмэнд хуваагдахаас хааны шууд захиргаанд зөвхөн гурван түмэн л харьяалагдаж байжээ.²³ Энэ үед “Дээр хөхрөгчид наран, саран хоёр, Доор хөрстөд хаан, жонон

²² Саган Сэцэн. Эрдэнийн товч. (Сонгомол эх бэлтгэж, хөрвүүлэг, тайлбар зүүлт хийсэн Баярсайхан М). УБ., 2006. Тал 107.

²³ Монгол улсын түүх. III боть. УБ., 2003. Тал 39.

хоёр”²⁴ гэсэн хэлц үг үүссэн нь тухайн үеийн уламжлалт хоёр гарын тогтолцоог илтгэн харуулдаг.



XII зуунаас өмнө ба дараа үед монгол нутагт оршиж байсан нүүдэлчдийн төрийн тогтолцоонд тодорхой харагдах “Хоёр гарын тогтолцоо” XII зууны монгол нутаг дахь улсуудын дотоод зохион байгуулалтын үндсэн загвар болж байсан нь эргэлзээгүй юм. Үүний баталгаа нь XII зууны монгол язгууртнууд улсыг их гэр тэрэгтэй зүйрлэж, улсыг удирдах явдлыг их гэр тэрэгний хоёр аралтай зүйрлэн хэлэлцэж, тайлбарлаж буй түүхэн мэдээ баримт болно.

Үүнийг Монголын нууц товчоонд *qoyar kil<ü>gütei tergen nökö'e kil<ü>gü-ben ququra'asu hüker inu jikdün yadayu tere metü nökö'e kil<ü>gün cinu bi ese-'ü aju'u* “Хоёр килгүтэй тэрэг нөгөө килгүгээ хугарваас үхэр нь зүтгэн ядью энэ мэт нөгөө килгүн чинь би эс ажгуу.” хэмээн тэмдэглэжээ. Энэ мэдээг эртний монголчуудын төрийн байгуулалтын уламжлалт гүн ухааны хураангуй томёолол гэж үзэж болох юм.

The traditional concepts of state administration in “The secret history of the Mongols”

This paper does consider the Mongols traditional concepts of state administration in the Secret history of the Mongols. The ulus is divided into two major administrative branches. The khan or the Ruler administers the left arm (wing), and the right arm (wing) is administered by the manager assigned by the khan whose title is taizi. Maybe It can be called the "Great Carriage Theory of the Nomadic State formation."

²⁴ Саган Сэцэн. Эрдэнийн товч. (Сонгомол эх бэлтгэж, хөрвүүлэг, тайлбар зүүлт хийсэн Баярсайхан М). УБ., 2006. Тал 115.